



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 2/660

Хэрлэн сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 23 дугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 23 дугаар хуралдааны 02 дугаар тогтоолын 2, 4 дүгээр хавсралтаар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтаас сумдад эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, цахим системийн худалдан авах төлөвлөгөөний хугацааны дагуу шуурхай зохион байгуулах, он дамжсан санхүүжилттэй төсөл, арга хэмжээг 2024 онд бүрэн дуусгаж хүлээлгэн өгөхөөр тендерийн баримт бичиг, ажил гүйцэтгэх гэрээнд тусгах, 2024 оны 4 дүгээр сарын 01-нд багтаан шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж худалдан авах ажиллагааг бүрэн дуусгах, тус ажлуудын захиалагчийн техник хяналтыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай гэрээ байгуулан хэрэгжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Г.Лхагвахатан)-т, барилга угсралт, их засварын ажлын захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Сүнгээ)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны дугаар захирамжийн хавсралт

Д/д	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг	2024 онд санхүүжих	Эрх шилжүүлсэн ТЭЗ
		Эхлэх	Дуусах			
<b>Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт</b>						
1	Орон сууц хорооллын иж бүрэн спорт тоглоомын талбай (Бор-Өндөр)	2024	2025	250,000.0	125,000.0	Бор-Өндөр сумын Засаг дарга
2	Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, гадна цахилгаан хангамжийн ажил (Дэлгэрхаан сум)	2024	2025	200,000.0	100,000.0	Дэлгэрхаан сумын Засаг дарга
3	Сумын төв доторх 0.4кв-ын цахилгаан хангамжийн ажил, камержуулалтын ажил (Норовлин сум)	2024	2025	152,000.0	100,000.0	Норовлин сумын Засаг дарга
4	Өмнөдэлгэр сумын 640 хүүхдийн сургуулийн цэвэр усны шугамд холбох ажил (Өмнөдэлгэр сум)	2024	2024	54,600.0	54,600.0	Өмнөдэлгэр сумын Засаг дарга
<b>Нийт дүн</b>				<b>656,600.0</b>	<b>379,600.0</b>	
<b>Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх их засварын төсөл, арга хэмжээний жагсаалт</b>						
1	Ахмадын байрны засвар, тоног төхөөрөмж (Мөрөн сум)	2024	2025	114,900.0	70,000.0	Мөрөн сумын Засаг дарга
2	Нэгдсэн халаалтын зуухыг шинэчлэх (Баян-Овоо сум)	2024	2024	120,000.0	120,000.0	Баян-Овоо сумын Засаг дарга
<b>Нийт дүн</b>				<b>234,900.0</b>	<b>190,000.0</b>	